

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

(үргэлжлэл, түрүүч нь өмнөх дугаарт)

Ц.Баатар¹

Глобалчлал нь хэд хэдэн субъектыг олон улсын харилцаанд гаргаж ирснээр тэдгээрийн шийдвэр, үйл ажиллагаа одоо дэлхий дахины үйл явцад чухал нөлөө үзүүлэх боллоо. Энэ бол Олон улсын валютын сан, Дэлхийн банк, ЮНЕСКО, НУБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага, “Их найм” зэрэг олон улсын болон, бүс нутгийн байгууллагууд (нийтдээ 60 орчим тийм байгууллага байдаг), олон үндэстний корпорациуд /60 мянга орчим/, хөрөнгө оруулагчид (тэтгэврийн болон хөрөнгө оруулалтын сангууд, даатгалын компаниуд), засгийн газрын бус байгууллагууд (“ногоонтны” хөдөлгөөн, “хил хязгааргүй эмч нар” г.м), томоохон хотууд (Лондон, Нью-Йорк, Токио, Франкфурт, Парис), бодгалиуд (эрдэм шинжилгээний ажилтнууд, их сургуулийн профессорууд, жүжигчид, Ж.Сорос, Б.Гейтс мэтийн хувь хүмүүс) юм. Эдгээрээс глобал гол “жүжигчин” болох АНУ, олон үндэстний корпораци, хотууд, бодгалиуд гэсэн эдгээр субъектыг тодорхой авч үзвэл зохино.

Олон улсын, улс хоорондын болон засгийн газрын бус байгууллагууд олноор байгуулагдаж байгааг глобалчлалын үйл явцын нэг онцлог шинж гэж болох юм. Одоо дэлхий дээр нэг мянга гаруй засгийн газар хоорондын байгууллага идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс 100 гаруй байгууллагын үйл ажиллагаанд зонхилох гүрнүүд тогтмол оролцож байгаагийн дотор Дани 164, Франц 155, Их Британи 140, АНУ 122, Канад 110, Япон 106, Бразил 100 байгууллагын гишүүн юм.

Орчин үеийн ертөнцөд Америкийн улсуудын байгууллага (АУБ), Нефть экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК), Лалын бага хурал байгууллага (ЛБХБ) зэрэг байгууллага багагүй үүрэг

¹ Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D). дэд профессор

гүйцэтгэж байгаа төдийгүй тооны хувьд улам олшрохын зэрэгцээ нэгэнт оршин буй байгууллагуудын үүрэг өргөжиж байгааг тэмдэглэвэл зохино.

АНУ, Канад, Мексикийн оролцоотой Умард Америкийн чөлөөт худалдааны бүс \НАФТА\ байгуулагдах үйл явц нэгэнт эхлэв. Ази-Номхон далайн эдийн засгийн зөвлөл \АПЕК\ байгуулагдав. Ази тивд Зүүн-Өмнөд Азийн улсуудын холбоо, Азийн хөгжлийн банк, бусад холбоо, нэгдэл үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Янз бүрийн орны улс төрийн намууд болон үндэстэн дамнасан корпорациудын хамтын ажиллагаа улам их цар хэмжээтэй болж байна.

Их долоо буюу аж үйлдвэрийн талаар хамгийн их хөгжсөн долоон орон-АНУ, Герман, Франц, Их Британ, Япон, Итали, Канад эдийн засаг, гадаад бодлогын нэн чухал асуудлуудаар жил бүр зөвлөлгөөн хийдэг болсон нь чухал ач холбогдолтой хүчин зүйл болов. 1997 оноос Их долоод Орос улс нэгдсэн билээ. Эдийн засгийн өсөлтийг хангах, гадаад эдийн засгийн харилцааны тэнцвэрт бус байдлыг багасгах, инфляц, ажилгүйдэл зэрэг дэлхий нийтийн хэмжээний тулгамдсан асуудал Их наймын зөвлөлгөөний анхаарлын төвд байх боллоо. Үүний сацуу цэрэг-стратегийн, гадаад бодлогын асуудалд улам бүр их анхаарах болов.

Бүрэн эрхт улсуудын зэрэгцээгээр олон улсын харилцааны хөгжлийн шинж чанар, хандлагал нөлөө үзүүлдэг янз бүрийн байгууллага, нэгдэл, бүтцүүд олон улсын харилцааны идэвхтэй субъект болж байгаа нь илэрхий. Дэлхийн хамтын нийгэмлэгийн оршин тогтнолт, хөгжлийн хандлагалд мэдэгдэхүйц нөлөөлж буй үндэстэн дамнасан корпорациудын үүрэг ихэсч байна. Үндэстэн дамнасан корпорациудын хэмжээнд гаргаж буй шийдвэрүүд тухайлсан орнуудын иргэдийн амьдралд тэдгээрийн засгийн газраас гаргаж буй шийдвэрүүдээс ч илүү их нөлөөлөх нь өнөө үед олонтаа болох хандлагатай болжээ.

Энэ бүх байгууллага, нэгдэл, корпораци нь янз бүрийн улсууд дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээнд ажиллах цогц журмыг боловсруулж хэвшүүлэхэд тус дөхөм үзүүлсэн юм. Тэдгээр нь хамтран ажиллах, мөргөлдөөнийг зохицуулах, дайнаас сэрэмжлэх, глобал эдийн засгийн өсөлтийг хангах зарчмуудыг тодорхойлж байна.

Олон улсын байгууллагууд нь дэлхий дахины, бүс нутгийн,

орон нутгийн түвшинд ажиллаж байна. Эдгээр байгууллагын зарим нь газарзүйн байрлалаараа төдийгүй бас ажил үүргийнхээ дагуу нэгдсэн байна. Олон улсын байгууллагын нэг биш харин хоёр систем оршиж байна гэж өрнөдийн хэд хэдэн шинжээч үзэж байна. Эхнийх нь Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн, хориг тавих эрх бүхий таван улсаас бусад бүх улс эрх тэгш оролцдог НҮБ хэмээх түгээмэл систем. Хоёр дахь нь нэлээд хязгаарлагдмал гишүүнчлэлтэй бөгөөд зах зээлийн эдийн засаг, улс төрийн ардчилалд үнэнч аж үйлдвэрийн талаар хөгжингүй орнуудыг нэгтгэдэг систем юм. Хоёр дахь системд НАТО \19 орон багтдаг\, Европын холбоо /ЕХ/, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага/ Organization for Economic Co-Operation and Development (OECD)/, НАФТА зэрэг багтана.

Олон улсын байгууллагын хоёр систем хоёулаа нийтлэг гишүүнчлэлтэй. Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Дэлхийн Худалдааны байгууллага нь НҮБ-ын системд албан ёсоор багтдаг бөгөөд орон бүхэнд нээлтэй байдаг. Гэхдээ тэдгээрийн үйл ажиллагаанд тавих жинхэнэ хяналт аж үйлдвэрийн талаар хөгжингүй орнуудын гарт байдаг. Энэ үүднээс “Их найм” онцгой үүрэгтэй. Түүний үүд хаалга буурай болон дунд зэргийн хөгжилтэй орнууд, тэрчлэн жижиг орнуудад үнэндээ хаалттай байдаг билээ. “Их найм” нь орчин үеийн дэлхий дахины эдийн засгийн үндсэн параметруудыг олон талаар тодорхойлох боллоо.

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Улс төрийн бодлого глобалчлагдаж байгаа нь олон улсын харилцаанд улс үндэстнүүдийн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөхөд хүргэв. Төвд тэмүүлэх хандлага хийгээд бүсчлэл, глобалчлалын үйл явц тухайлсан орнуудын ч, олон улсын улс төрийн нийт системийн үүрэгт ч ихээхэн нөлөөлөх болов.

Хэдхэн арван жилийн өмнө дотоод, гадаад бодлогыг зөвхөн тухайн улсын үүрэг гэж үздэг байлаа. Олон улсын харилцааны хүрээнд тухайлсан улсууд үндэсний эрх ашгаа хэрэгжүүлэхийн тулд бие биетэйгээ харилцан холбоо тогтоодог байлаа. Улс бүхэн дангаараа юмуу бусад улстай эвсэж үйл ажиллагаа явуулахаас үл шалтгаалан өөрийн батлан хамгаалахын болон аюулгүй байдлын

асуудлаа өөрснөө бие даан шийдвэрлэж байв. Энэ утгаар XIX зууны турш “гялалзтал бие даах” бодлогоороо бахархаж ирсэн Их Британи, дэлхийн хоёрдугаар дайн хүртэл бусад улстай “зайлшгүй холбоо” тогтоохыг няцааж ирсэн АНУ хоёрыг тэмдэглэмээр байна.

Дэлхий дахин тухай тухайн хэсгүүд нь бие биетэйгээ нягт холбоотой нэгдмэл цогцолбор болж байгаа өнөө үед байдал нэгэнт өөр болсон буюу наанадаж ихээхэн өөрчлөлт орлоо.

Шийдвэр гаргах үйл явц нарийн төвөгтэй болсны улмаас засгийн газрууд уян хатан байж, нийгмийн өмнө үүссэн асуудлыг түргэн тусгаж авах бололцоогүй болов. Түргэн, үр нөлөөтэй шийдвэр гаргахыг шаардсан хямралт, онцгой нөхцөл байдалд удирдлагын хүнд сурталт аппарат гайхмаар арчаагүйгээ харуулж байна. Нийгмийн амьдралын янз бүрийн хүрээ, түвшинг хамарсан гүнзгий өөрчлөлтүүдийн огтлолцооны цэг дээр ирсэн зарим улс орны удирдлагын хүрээнийхэн төрөл бүрийн, заримдаа өөр хоорондоо зөрчилдсөн шийдвэр гаргах болсон нь үндэсний эрх ашгаа цэгцлэн хамгаалахад улам бүр бэрхшээлтэй болгож байна. Энэ нь улс төрийн зүтгэлтнүүд, байгууллагууд, засгийн газрууд, улс орнуудын үйл явдлыг хянах, шийдвэр гаргаж хэрэгжүүлэх чадвар нь түрүүчийн адил тэдний бололцоо, өөрийн улсын дотоодын эрх мэдлээс төдийгүй бас гадаад ертөнцийн байдлыг харгалзаж, тэдэнд нөлөөлөх чадвараас нь шалтгаалж байгаа зэрэг олон хүчин зүйлийн нөлөөллөөр тодорхойлогдоно. Энэ утгаар авч үзвэл, янз бүрийн бүс нутагт үүсч байгаа төрөл бүрийн, өөр хоорондоо сүлжилдсэн, мөн хэсэг бусаг асуудлыг гол төлөв төрийн албан ёсны байгууллагууд, бүтцүүдийн хэрэглэдэг албан ёсны уламжлалт арга хэрэгсэлээр \гэрээ байгуулах тухай хэлэлцээ хийх, дипломат харилцаа тогтоох юмуу таслах г.м\ шийдвэрлэх аргагүй болох явдал олонтаа тохиолдож байгаа нь багагүй учир холбогдолтой юм. Хүний аж төрөх орчныг хамгаалах, сэргээгдэшгүй нөөц барагдах, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрэх аюул бий болох зэрэг цогц глобал асуудал тэргүүн зэрэгт дэвшигдэн тавигдахад тухайлсан орон бүрийн засгийн газрын өмнө тулгарч байгаа бэрхшээл улам бүр хүндэрч байна. Энд эдийн засгийн хүрээнд гарч буй өргөн цар хүрээтэй ахиц өөрчлөлт, өсөлт бууралт зэрэг гол зангилаа асуудлууд улс төрийн шийдвэр гаргах үйл явцад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх болов. Үүнтэй холбогдуулан Нью-Йоркийн их сургуулийн профессор Р.Кокс 60-70-аад оны сүүлчээр

ажиглагдсан төрийн оролцооны системийн хямралыг олон улсын эдийн засгаас глобал эдийн засагт шилжсэн шилжилтийн үр дагавар гэж үзэж болохыг анхааруулсан байна.

Олон улсын эдийн засгийн системийн үед улс орнууд өөрийн эдийн засгийг үлэмж хэмжээгээр хянаж, гадаад эдийн засагтай тогтоосон харилцааг зохицуулж чадлаа байлаа. Бреттон-Вудын хэлэлцээрийг энэхүү зохицуулагч үүргийг хэрэгжүүлэх үйлсэд улс орнууд өөр хоорондоо хамтран ажиллах хэрэгсэл гэж үзэж байлаа. Одоо бүрэлдэж буй глобал эдийн засагт улсуудын энэхүү бие даасан үүрэг үлэмж сулрав. Энэ нөхцөл байдалд ер нь аль ч улс үндэснийхээ эдийн засгийг үл зохицуулагдах глобал эдийн засагт уян хатан зохицуулах үүрэг л үлдээд байна гэхэд нэг их хэтрүүлэг болохгүй биз ээ. Хараат эдийн засагтай, буурай хөгжилтэй, донор орнуудын амь тариагаар гол зогоож буй Монгол улсад ч дээрхи асуудал мөн нэгэн адил хамаарна. Глобалчлалын өнөөгийн нөхцөлд бие даасан улсуудын хувьд үндэсний эдийн засгийн хоорондын хил хязгаар улам бүр үгүй болж байгаагийн улмаас урьд өмнө зөвхөн дотоод улс төрийн гэгдэж байсан асуудлууд одоо олон улсын улстөрийн шинж чанартай болж байна. Ингэхдээ тийнхүү харилцан сүлжилдэх нь нийгмийн амьдралын бүх маш чухал хүрээнд ажиглагдаж байна. Америкийн эдийн засагч У.Смайзерын тэмдэглэснээр, “санхүүгийн ертөнц нь цаашид дотоод, гадаад эдийн засгийн бодлогын хоорондуур хил татахаа больсон. Энэ хоёр хоёул бие биендээ нэвчиж, глобал зах зээлийн нөхцөлд хөгжингүй орнуудаас хөгжиж буй орны эдийн засагт үзүүлж буй уршигт үр дагавар хор хохирлыг хөгжиж буй орнууд хэрхэн тэсч гарах тэр л ур чадварын хэрээр дээрхи хоёр бодлого бие биенээ бүрэлдүүлж буй” аж.

Улс төрийн болон бусад харилцаа улсын хилээс хальж байгаа нь аль нэг улс тодорхой дэвсгэр нутгийг гагцхүү өөрийн харьяаных байлгах тухай үзэл санааг бодит байдалд тун бага нийцэхүйц болгох тийм их учир холбогдолтой болгосон, болгосоор байна. Нэг талаас, чухам юу дотоод бодлогын эрх мэдлийн хүрээнийх болох, юу нь гадаад бодлогын эрх хэмжээний болох вэ гэдгийг батлахад улам бүр бэрхшээлтэй болж байхад нөгөө талаас, гадаад бодлогын дотоод улс төрийн үр дагавар, дотоод бодлогын гадаад улс төрийн үр дагаварын учир холбогдол өсөн нэмэгдэж байна.

Дотоод бодлогын асуудлууд олон улсын бодлогын бүрдэл хэсгийг өөрийн салшгүй хэсэг болгон агуулах болсон нь илэрхий болсон учраас энэхүү асуудлыг онцгой анхаарвал зохино. Үүний үр дүнд нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зан заншил, улс төрийн удирдлагын практик нь засгийн газрууд асуудлаа өөрсдөө шийдвэрлэхэд нэгэнт хангалтгүй болж байна.

Тэдгээрийн өөрчлөлтөд дасах чадвар нь нийгмийн өмнө үүсч байгаа бүх асуудлыг шийдвэрлэх нөөц дутагдалтайгаас болж байна. Тэрчлэн улс орнууд гадаадын хэрэг явдлын байдал, гадаад түншүүдтэй тогтоосон хамтын ажиллагаанаас улам бүр хамаараалтай болж байгаагийн улмаас буурсан байна. Улсуудын бие даасан байдал, бололцооны цар хэмжээ багасч байгаагийн эрхээр улс нэг бүрийн эргэн тойрны нөхцөл байдал бас улам бүр нарийн ээдрээтэй болж байна. Ингэхлээр улс орнуудын хувьд гадаадаас дэмжлэг хайх, хамтран ажиллах явдал улам бүр хүнд зорилт болон тавигдах нь. Цар хүрээ, хууль ёсны байдал, үр ашигт чанар хумигдаж байгааг харуулсан шинэ нотолгоо бүхэн олон улсын харилцааны бүх субъектыг эрх мэдэл, нэр хүндийн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг үл ойшоож, үйл ажиллагааны өөрийн гэсэн журам дэвшүүлэхэд хүргэж байна.

Засгийн газрууд бусад улсын дотоод бодлогод ямар нэг нөлөө үзүүлэхээргүй цэвэр өөрийн улсын дотоодын шийдвэр гаргаж болох хүрээ улам бүр хумигдсаар байна. Ялангуяа мэдээлэл зүй, харилцаа холбооны салбарт гарч буй технологийн өөрчлөлтийн хурдац энэхүү үйл явц түргэсэхэд нэмэр болж байна. Үндэсний эдийн засгийн бие даасан байдалтай холбоотой шинэ асуудлууд мэдээллийн чөлөөт урсгал үүсгэж, түүнийг улам бүр чухал болгож байна. Үндэсний засгийн газрууд аж үйлдвэрийн олон үндэстний нэгдлийн хэлбэрээр улам бүр өргөжиж байгаа мэдээллийн салбаруудыг үр ашигтай хянах чадваргүй болж байна. Хиймэл дагуулын холбооны систем нь мэдээллийн урсгалд тавих үндэсний хяналтад мөн иймэрхүү асуудал үүсгэж бас чадах юм. Эндээс дүгнэвэл, хэрэв урьд өмнө гадаад бодлогыг дотоод бодлогоос харьцангуй ангид хэрэгжүүлж болдог байсан бол одоо тэдгээрийн хооронд зааглах тодорхой шугам татахад улам бүр бэрх болж байгаа нь тодорхой. Ж.Розенау ийм үзэл бодлыг үндэстэй гэж үзээд дараах баримтыг дурджээ. Нэг л онд, зөвхөн олон улсын асуудал эрхлэдэг байгууллага олон улсын харилцааны зөвлөл

АНУ-ын гадаад бодлогыг боловсруулах дотоодын үндсүүдийг судлах хэсэг байгуулсан бол дотоод бодлого боловсруулж хэрэгжүүлэх практикийг сайжруулах ажил эрхэлдэг ардчилсан институудыг судлах төв олон улсын бодлогын асуудлаар бага хурал хийлгэж байжээ.

Одоо Вашингтонд гадаадын 40 орчим корпорацийн лоббист товчоо ажиллаж байгаа нь сонирхолтой зүйл. Эрчим хүчний салбарт явуулах бодлогыг олон мэргэжилтэн, төрийн зүтгэлтэн “дайны ёс суртахууны эквивалент” гэж үздэг нь тэмдэглүүштэй зүйл. Энэ бүх үйл явц, хандлага нь олон улсын бодлогын субъект болсон тухайн орнуудын үүргийг тодорхой хэмжээгээр багасгахад нэрмээс болжээ. Орчин үеийн дэлхийн хамтын нийгэмлэгт харилцааны наанадаж гурван цогцолбор байна. Энэ нь тухайн орноос бусад улсуудтай харилцах харилцаа, улсуудаас корпорациуд хийгээд олон улсын байгууллагуудын харилцаа, тэрчлэн корпорациуд хоорондын харилцаа юм. Бие даасан үндэстэн улс үйл ажиллагааны үндсэн нэгж нь болж байсан олон улсын систем үлэмж өөрчлөгдлөө гэж хэлж болох байна.

Олон улсын харилцааны хүрээнд улс төрийн бодлогын гол, тэр ч байтугай цорын ганц субъект болж байсан улс өнөөдөр улс төр, эдийн засгийн бүрэн бие даасан зүйл байхаа больж, дэлхий дахины улс төрийн систем, дэлхийн эдийн засаг, дэлхийн хамтын нийгэмлэг гээч илүү өргөн зүйлийн зөвхөн нэг хэсэг нь болж байна гэсэн санал ч байдаг. Энэ үүднээс авч үзвэл, олон тохиолдолд дэлхийн улс төрийн үйл явцад улс орнуудын зэрэгцээ үндэстэн дамнасан байгууллагууд, түүнчлэн улс орнуудаас үл шалтгаалан оршин тогтнож, үйл ажиллагаа явуулж байгаа хүчин оролцож байгаа нь багагүй чухал ач холбогдолтой юм. Тэдгээрийн үүрэг өсөн нэмэгдэж байгаа нь нэг улс үндэстэний хүчин зүйлийг эвдэж байна. Энэ нь олон улсын харилцааны үндэстнээс дээгүүрх, улсаас дээгүүрх субъектуудын эрх өргөжиж байгаагийн улмаас төдийгүй бас бүс нутгууд хүчирхэгжиж байгаагийн улмаас улсуудын бүрэн эрхт байдал суларч байгаагаар холбоотой юм.

Үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагааны хүрээ өргөжиж, ихээхэн хэмжээний капитал хөдөлгөөнд орж байгаагийн үр дүнд тухай тухайн орнуудын хоорондын эдийн засгийн хил хязгаар аажмаар нийлж байна. Дэлхийн банк, олон улсын валютын сан болон санхүүгийн бусад байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж

байна. Олон улсын валютын сан нь анх үүсгэн байгуулсан 35 орны авсаархан нэгдлээс дэлхийн эдийн засгийг бүхэлд нь хамарсан байгууллага болж хувирав. Эдгээр байгууллага болон тухай тухайн орнуудын хоорондын олон талт хэлхээ холбооны систем бүрэлдэж, хэлбэрэлтгүй өргөжсөөр байна. Түүгээр ч барахгүй эдгээр байгууллага улс үндэстнүүдийн үйл ажиллагааны эрх мэдлийн хүрээнд нэвтэрч байна. Энэ бүхэн нийлээд тухай тухайн бүс нутгуудын хүрээнд улс орнуудын хоорондын үйлдвэрлэлийн зохион байгуулалт, үр ашгийн түвшингийн ялгааг багасгахад хүргэж байна.

Ийм нөхцөлд үндэстний эдийн засгууд бие биендээ харилцан нөлөөлөх цар хэмжээ өсөн нэмэгдэж байна. Түүгээр ч барахгүй энэ нөлөө амьдралын бараг бүх хүрээнд мэдрэгдэж байна. Тухайлж авч үзсэн орон нэг бүрийн менежментийн шилдэг системийг ажилгүйдэл, мөнгөний ханш уналт, эдийн засгийн бууралт, технологийн хоцрогдол, эдийн засгийн хөгжлийн хурдцын тэнцүү биш байдал зэрэг үндэсний эдийн засгийн асуудлуудтай тулгарч байсан засгийн газар боловсруулсан байдаг билээ. Өнөөдөр эдгээр асуудал нь үндэсний гэхээсээ олон үндэстний шинж чанартай болжээ. Нэг орны эдийн засгийн бууралт, ажилгүйдлийн өсөлт бусад оронд экспортлогдох нь олонтаа байна. Үүнийг Америкийн эдийн засаг найтаалгаж эхэлвэл дэлхийн эдийн засаг уушигны хатгаа авдаг болж байна гэхчилэн дүрслэн хэлж болох байна. Өнгөрсөн онд Америкт террористуудын явуулсан түрэмгийлийн уршгийг давж гарахын тулд дэлхийн санхүүгийн байгууллага, Европын холбоо, Япон хэрхэн уялдуулан зохицуулсан бодлого явуулж ханшны уналтыг тогтоон барьж чадаж байгааг бид харж байна. Бас нэг жишээ хэлье. Герман, Японы эдийн засгийн өсөлтийн хурдац ихэд удааширвал бусад хөгжингүй орнууд нийт дэлхийн эдийн засгийн эрх ашгийн үүднээс өсөлтийг хангах арга хэмжээ авахыг Герман, Японы эрх баригчдаас царайчлан гуйдаг болжээ. Жишээлбэл, нефть экспортлогч орнууд нефтийн үнийг нэмбэл энэ нь дэлхийн зах зээлүүд дээр бусад таваарын үнийн түвшинд нөлөөлдөг ба аж үйлдвэрийн талаар хөгжингүй орнуудад аж үйлдвэрийн барааны үнэ нэмэгдвэл шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын үнийн түвшинд зохисгүй нөлөөлдөг жишээтэй. Мөн Нью-Йорк, Лондонд тогтоосон хүүгийн хэмжээ дэлхий дахинд хүүгийн хэмжээг аяндаа тодорхойлж байдаг билээ. Нэг орны гаалиар хавчих бодлого бусад олон орны худалдаанд нөлөөлөхгүй байх аргагүй.

Санхүүгийн зах зээлүүд, тэр ч байтугай зарим томоохон санхүүчид, эсвэл байгууллагууд төрөөс гаргадаг улс төрийн шийдвэрийн үр дүн, эдгээр шийдвэрийн шинж чанарт ихээхэн нөлөөлж чалдаг болжээ. Америкийн эдийн засагч У.Смайзер ийм байдлыг тайлбарлахдаа, Франкфурт дэх Германы Бундесбанкны ерөнхийлөгчийн албан тушаалд аль нэг хүнийг томилох явдлыг америкчууд АНУ-ын дотоодод аливаа дээд тушаалд ямар нэг гарамгай америк хүнийг томилохыг анхааран сонирхдогийн адил сонирхдог болж байна гэж тэмдэглэжээ. Учир нь Бундес банк АНУ-ын эдийн засагт гүн гүнзгий, улам бүр нэвтрэн орж ихээхэн нөлөөтэй болсныг гэрчилж буй хэрэг.

Санхүүгийн үлэмжхэн хөрөнгөтэй бусад орны банкнуудын тухайд ч ингэж хэлж болно. Америкийн тоймч Т.Люк эдгээр болон үүнтэй төстэй үйл явцуудыг задлан шинжлээд, санхүүгийн зонхилох төвүүд гэсэн ойлголт өөрөө харилцаа холбооны төвүүд нэвтэрсэнтэй уялдаад учир утгагүй болжээ гэсэн дүгнэлт хийсэн байна. Ийм нотолгоо нь нэлээд хэтрүүлсэн шинжтэй ч Токио, Гонконг, Сингапур, Сөүл, Стамбул, Каир, Москва нь Парис, Лондон, Ром, Берлин, Нью-Йорк, Сан-Франциско зэрэг эртний төвүүдтэй эн зэрэгцэн дэлхийн эдийн засгийн тулгуур төвүүд болон хувирч байна.

Эдгээр болон эдгээртэй холбоотой бусад өөрчлөлт, эдийн засгийн хүрээний ахицын үр дүнд үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон геополитикийн бүх цогц асуудал шинээр тавигдаж байна. Баахан хялбарчилж үзвэл, урьд өмнө олон улсын тавцанд эрх мэдэл, нөлөөний төлөө тэмцлийг улс орнууд арми, үзэл суртлын тусламжтайгаар хийж байсан бол одоо энэ тэмцэл валютын ханш, зээлийн хүү, зах зээлийн ашигт ажиллагаа зэргийн хүрээнд шилжин орсон байна гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл Америкийн тоймч М.Хиршийн бичсэнчлэн “хуучин тоглоомыг шинэ дүрмээр тоглох” болжээ. Бидний ирээдүй шөнийн харанхуйд зэвсэг хангинуулагч бүдүүлэг армиудаас бус харин хоногт 24 цаг ажилладаг ажилсаг санхүүчдээс улам бүр шалтгаалж эхэлж байна. Тэд компьютерийн товчлуурууд дээр ганцхан дарснаар сулхан валют руу довтолж, эсвэл бодлогогүйгээр татвараа нэмсэн орноос ухарч гарах дохиог дэлхий дахины капиталд өгч чадна. Өөрөөр хэлбэл цэрэг, дайны бодит байдал глобал стратегийг тодорхойлж, эдийн засгийн байдлыг хянаж байсан хүйтэн дайны үеийг болвол одоо

эдийн засгийн бодит байдал нь дэлхий дахиныг тодорхойлон бүрэлдүүлж байна. Р.Туз энэ үйл явцыг тайлбарлахдаа, “олон улсын эдийн засаг” гэдэг ойлголтыг “дэлхийн улс төрийн эдийн засаг” гэдэг ойлголтоор солихыг санал болгожээ.

Улсуудын хүчин чадлын өгөгдөхүүнүүдийг ч, тэдгээрийн гадаад бодлогын дүр зураг, чиглэлийг тодорхойлоход ч эдийн засгийн хүчин зүйлийн үүрэг илэрхий улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь судлаачдыг геополитик оролдоггүй юмаа гэхэд геоэдийн засгийн тухай санал бодол дэвшүүлэхэд хүргэжээ.

Зэвсэглэлээр хөөцөлдөх явдал багасахын сацуу эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хүрээнд өрсөлдөөн ширүүсч байна. Энэхүү өрсөлдөөнийг зохицуулах хэлбэрүүд нь дэлхийн эдийн засагт төдийгүй олон улсын аюулгүй байдал, улс төрийн харилцааны илүү өргөн хүрээнд ихээхэн нөлөөтэй байх болно.

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛЫН НӨХЦӨЛ ДЭХ БУУРАЙ ХӨГЖИЛТЭЙ ОРНУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эдийн засгийн глобалчлал нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудын орлогын ялгааг урьд хожид байгаагүй ихээр нэмэгдүүлж байна. Зөвхөн хөдөлмөрийн хөлсийг аваад үзье. Энэ нь 1995 онд Германы боловсруулах аж үйлдвэрт цагт 32 доллар, Японд 24, АНУ-д 17, Их Британид 14 доллар байлаа. Гэтэл 1998 оны тавдугаар сард Жакартын тэнгисийн боомтол 6 мянган ажилчин бүтэн өдрийн цалин хөлсөө 50 цент байгааг нэг доллар хүртэл нэмэгдүүлэхийг шаардаж ажил хаясан тухай мэдээ үнэхээр цочирдуулсан юм. Тэгвэл Германы ажилчин хүн 10 цаг ажиллаад үүнээс дутуугүй мөнгө авч байна.

“Дэлхийн эдийн засаг суларвал Өрнөд цэцэглэн хөгжиж байдаг. Ялгаа зааг гайхалтай их, тэр ч байтугай үзэгдэж харагдаагүй их байна... Өрнөд болон бусад ертөнцийн хоорондын ялгаа гүн ангал болон хувирч байна” гэж Лондоны “Файнэншл Таймс” сонин тэмдэглэжээ. Европын орнууд хийгээд далайн чанадаас бусад ертөнц рүү ихэмсэгээр ажиглаж суудаг АНУ-ын хоорондын зай улам холдож байгаад Английн ажил хэрэгч хүмүүсийн хэвлэл болох тус сонин түгшиж байна. “АНУ бол мөнхийн цэцэглэлт хөгжилт баталгаатай болсон төдийгүй АНУ эдийн засгийн цорын ганц зөв загвар, цорын ганц гэрэл гэгээний эх үүсвэр хэмээн

америкчууд үзэж байна” гэж тус сонин егөөдөн тэмдэглэжээ. Энэ бол хэтрүүлээгүй дүгнэлт. Тухайлбал энэ талаар Европ-Азийн сангийн ерөнхийлөгч Чарльз Уильям Мэйсон Америкийн нөлөө бүхий “Форин полисы” сэтгүүлд бичихдээ, “Одоо америкчууд нийтийн өмнө үг хэлэхдээ дараах байдлыг тодорхойлдог боллоо. Үүнд тухайлахад тус улсын хоёр гол намын нөлөө бүхий зүтгэлтэн хэн гуай ч байлаа гэсэн гадаад бодлогын сэдвээр ярихдаа АНУ-г орлошгүй үндэстэн, цорын ганц их гүрэн, хосгүй хариуцлагатай улс, ертөнцийн цорын ганц ариун орон гэж байнга тодорхойлдог болжээ” гэсэн байна.

АНУ-г дэлхий дахины тааламжтай глобал гүрэн гэхэд Азийн орнууд ихэд сэжиглэн эргэлзэж байна. Азид үндэсний валютын ханш унаж, ажилгүйдэл өсөн үйлдвэрлэл багасаж, хувийн олон компани дампууран, хямрал жинхэнэ төрхөөрөө нэрвэхэд тэнд америкийг эсэргүүцсэн санаа бодол илэрхий өссөн билээ. 1997 оны зургадугаар сараас фондын зах зээлүүд дээр доллараар хийдэг гүйлгээний хэмжээ Индонезид 89 хувь, Өмнөд Солонгост 75 хувь, Малайзид 73 хувь, Таиландад 57 хувь, Гонконгт 47 хувь буурсан билээ. “Энэ бол цэгцтэй бууралт биш харин сандрал мөн гэж “Файнэншл Таймс” сонин тэмдэглэжээ. Гэтэл тэр зуур АНУ болон Өрнөд Европын зах зээл өрнүүн хөгжиж, үнэт цаасны ханш Азийнхтай харьцуулахад олон дахин өссөн билээ гэж тус сонинд бичжээ.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннаны үзэж байгаагаар, дэлхийн олон удирдагч, санхүүчид янз бүрийн орны эдийн засгийн харилцан хамаарлын өсөлтийн улс төрийн уршиг дагаврыг дутуу үнэлсэн ажээ. Ингээд одоо түүний төлөө ихээхэн үнэ төлөх болж байна. “Глобалчлал бол бодит байдлыг тусгасан үзэгдэл биш харин махчин капитализмын үзэл суртал юм шиг байна. Сая сая хүн зовж тарчлан, мөнгөн хадгаламж үгүй боллоо. Олон арван жилийн турш ядууралтай тэмцэж ихээхэн үнэ цэнээр олсон ахиц дэвшил үхлийн аюулд ороод байна гэж тэрээр онцлон тэмдэглэжээ.

Өнгөрсөн зууны сүүлийн арван жилд үндэсний аж ахуйнууд маш хурдацтай нээлттэй болов. 20 жилийн хугацаанд дэлхийн үйлдвэрлэлд дэлхийн экспортын эзлэх хувь /экспортын хувь хэмжээ гэгч/ 10-20 хүртэл хувь нэмэгдэж, түргэн өсч буй үйлчилгээний экспортыг харгалзвал 15-22 хүртэл хувь өсчээ.

Хувьцаа арилжаалагч 7 хүн тутмын нэг нь гадаадын түншүүдтэй харьцаж байна. Үндэстэн дамнасан компаниудын гадаад дахь салбаруудыг худалдах хэмжээ дэлхийн экспортын хэмжээнээс мэдэгдэхүйц давж гарлаа. Энэ бүхэн бол глобалчлалын үйл явц буюу таваар, үйлчилгээ, капиталын үндэсний зах зээлүүдийн харилцан хамаарал улам нэмэгдэж буй үйл явцын гэрч юм. Энэ нь бас хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, хэрэглээ, дэлхийн хэмжээгээр улам бүр харилцан сүлжилдэж байгаагийн гэрч юм. Энэ нь нээлттэй зах зээл, хатуу өрсөлдөөний нөхцөлд бэлэн бус байгаа дэлхийн аж ахуйн зах хязгаарын бүс нутгуудад түгшүүр төрүүлж байна. Тэдгээр бүс нутагт олон улсын эдийн засгийн харилцааг глобалчлахыг эсэргүүцэж байна. Ингэх болсны гол учир нотолгоо нь таваар үйлчилгээний худалдааг чөлөөтэй болгож, капитал экспортлогчдод найдвартай баталгаа олгон оюуны өмчийн эрхийг хамгаалах нь зөвхөн хэдхэн тооны баян оронд ашигтай бөгөөд Умард, Өмнөдийн техник-эдийн засаг, нийгмийн ялгаа зааг гүнзгийрч, олонхи орон хязгаарлагдмал болж, дэлхийн хамтын нийгэмлэгийг туйлшрахад хүргэнэ гэж үзэж байгаад оршино.

Глобалчлал бол хагас зуун жилийн өмнө эрх чөлөөгөө олсон тэр бүс нутгуудыг дахин колоничлох хэлбэр юм гэж Малайзийн ерөнхий сайд М.Мохамад эрсхэн хэлсэн байна. Түүний хэлснээр бол ядуу ард түмнүүдэд шүд, хумснаас өөр энэхүү хорлогон явдлын эсрэг тэмцэх хэрэгсэл байхгүй ажээ. Гэхдээ глобалчлал гэдэг өөрсдийнх нь хувьд чухам юу болохыг эдгээр ард түмэн ойлгохоороо нэг ёсондоо “партизаны дайн” хийж эхлэх болно гэж тэрээр цохон тэмдэглэжээ. Ийнхүү дэлхийн туйлшралын тухай тун буурь суурьтай судлаачид ч үгээ хэлж байна.

НҮБ-ын нэгэн тогтоолд дурдсанаар, 1980-1993 онд барагцаалбал 15 орны эдийн засаг эрс өсч, 1,5 тэрбум хүний амьдралын түвшинг дээшлүүлсэн бол 1,6 тэрбум хүн ам бүхий 100 гаруй бусад оронд эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж, орлого буурсан байна. Ингэхдээ тэдгээрийн дотроос 70 оронд нэг хүнд ногдох дундаж орлого 1980 оны түвшнээс, 43 оронд 1970 оны түвшнээс буурсан байна. Сүүлийн 15 жилд дэлхий дахин эдийн засгийн хувьд улс орнуудын хооронд ч, нэг улсын дотор ч илүү их туйлширсан байна. Хэрэв ийм хандлага үргэлжилвэл хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын хоорондын тэнцвэргүй байдал нь хүнлэг бус байдал болон зүй бусаар хувирах болно гэж дээрх тогтоолд тэмдэглэжээ.

Дэлхийн хүн амын 80 орчим хувь нь шинэ тулгар хөгжиж байгаа орнуудад аж төрж байгаа бөгөөд оршин суугчдын одоогийн өсөлтийн 94 хувь нь тэдэнд ногдож байна. Дийлэнх олонхи болж буй зол заяагүй өлсгөлөн хүмүүс хүн төрөлхтөний зургааны нэг хүрэхгүй хэсгийг бүрэлдүүлэгч хэдхэн тооны ямбатнууд тансаглан цэнгэж, жаргалд умбан байгааг улам бүр атаархан жигшиж, харсаар байгаа үед дэлхий ертөнц нэгдмэл тухай ярих нь ёс зүйд хэр нийцэх бол? Эдийн засаг хөгжин нарийсахын хэрээр, глобалчлал гүнзгийрэхийн хэрээр Умард, Өмнөдийн, баян ядуугийн хоорондын уламжлалт ялгаа багасаагүйгээр барахгүй харин ч нэмэгдэж байгаа нь гайхалтай боловч үнэн баримт юм. Дэлхийн зарим нутагт нийгэм шууд ялзран доголдож, амьдралын нөхцөл дээд зэргээр муудаж байна. Нийгмийн хоёр туйлын түүх эсрэг чиглэлээр хөдөлсөөр байгаа мэт дүр зураг харагдаж байна.

Глобалчлалыг хяналтдаа авахгүй бол бүх нийтээрээ баян цатгалан болохоосоо хүн төрөлхтөний олонхи нь ядуурахад хүрэх нь улам бүр тодорхой болж байна. Энэ талаар 1995 онд Копенгаген хотод болсон Нийгмийн конгресс, 1996 онд Ромд болсон хүнсний конгресс дээр дурдсан зарим мэдээг сийрүүлье. 1990-ээд оны эхээр дэлхийн бөмбөрцгийн хүн амын хамгийн ядуу давхаргуудад ногдог орлогын хэмжээ 1,4 хувь хүртэл буурчээ. Баячууд, ядуучуудын орлогын харьцаа 1960 онд 13:1 байснаа өнгөрсөн зууны сүүлийн арван жилд 60:1 болжээ. Дэлхийн бөмбөрцгийн хүн амын тавны нэг нь манай гаригийн баялаг, нөөцийн 85 хувийг хэрэглэж байхад 1,3 тэрбум хүн туйлын ядуу зүдүү байдалд амь зогоож байна.

Дэлхийн банкны тооцоолсноор, одоогийн хандлага хэвээр байвал XXI зууны эхээр манай гаригийн ядуучуудын тоо дахин 200 сая хүнээр нэмэгдэж болох байна. Одоо дэлхий дээр 100 сая гаруй хүн ажилгүй, 700 сая орчим хүн хагас дутуу ажилтай, нэг тэрбум хүн бичиг үсэг мэдэхгүй байна. Дэлхийн гурван хүн тутмын нэг нь цахилгаан хэрэглэж чадахгүй байна. 1,5 тэрбум орчим хүн ундны цэвэр ус хэрэглэж чадахгүй байна. Хоёр тэрбум хүн эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд толгой хоргодож байна. 840 сая хүн, түүний дотор 2 сая хүүхэд өлсөж, өлөн зэлмүүн амь зогоож байна. Ядуу орнуудад жил тутам 14 сая хүүхэд орчин үеийн анагаах ухааны эмчлэн эдгэрүүлж бүрнээ чадах өвчнөөр, 500 мянган эмэгтэйчүүд эмнэлгийн шаардлагатай

тусламж авч чадахгүй нас барж байна. Шинэ тулгар хөгжиж буй орнуудын хүүхдийн эндэгдлийн тэн хагас нь өлсгөлөнгөөс шалтгаалж байна.

Дэлхийн банк “Дэлхийн хөгжлийн санхүүжилтийн тухай” гэсэн илтгэлдээ сүүлийн саруудад дэлхий нийтийн эдийн засаг уналтад орох аюул багассан хэдий ч, хөгжиж буй орнууд 1982 оноос хойшхи эдийн засгийн өсөлтийн хамгийн удаашралтай хурдсын бас нэг жилийг туулах хэрэгтэй болж байгааг тэмдэглэжээ.

1968 онд 1,9 хувь байсан хуучин дорнодын эвслийн хөгжиж буй орнуудын өсөлтийн хурдац 1999 онд ойролцоогоор 1,5 хувь болж буурна. 1997 онд санхүүгийн хямрал болохоос өмнө энэ арван жилийн эхний хагаст өсөлтийн хурдац жил дунджаар 3,1 хувь байв. Дэлхийн худалдааны өсөлт удааширч, түүхий эдийн барааны үнэ унаж, гадаад санхүүжилт хомсдсон нь олонхи хөгжиж буй орны хүнд байдлын гол шалтгаан болсон билээ.

“Сүүлийн саруудад дэлхий нийтийг хамарсан гүнзгий уналтын эрсдэл багассан хэдий ч, төлөвшиж буй зах зээлтэй орнуудын хямрал түрүүнд таамаглаж байснаас илүү гүнзгий, илүү удаан хугацаагаар үргэлжилж болох юм” гэж ДБ-ны илтгэлд дурджээ. Энэ байдал нь тухайлбал, дэлхийн худалдааны хөгжлийн хэтийн төлөв муудснаар илэрч байгаа бөгөөд 1998 онд энэ худалдааны өсөлтийн хурдац 1997 оныхоос тэн хагасаас илүүгээр буурч, ДБ-ны үзэж байгаагаар 1999 онд 4,2 хувь болох ажээ. Үүний хамт 1998 онд нефтис бусад түүхий эдийн бараа таваарын үнэ 16 хувиар унаж, 1999 онд бас 6,3 хувиар буурах төлөвтэй байжээ. Гэтэл эдгээр түүхий эдийн барааны экспорт нь хөгжиж буй олон орны хувьд орлогын чухал эх сурвалж болж байдаг билээ.

Энэ бүхнээс болж дэлхийд, давын өмнө хөгжиж буй орнуудын нийгэм-эдийн засгийн байдал муудаж байна. ДБ-ны тооцоолсноос үзвэл, одоо дэлхийд өдөрт хоёр хүрэхгүй долларын орлоготой 2,7 тэрбум ядуу хүн байна. Энэ нь Монголд ч хамаарна. ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоолсноор, хэрвээ 1980 онд ЗХУ-д 14 сая орчим хүн ядуу зүдүү байдалд аж төрж байсан бол, 90-ээд оны дунд үе гэхэд зөвлөлтийн дараах орон зайд ядуучуудын тоо барагцаалбал 147 сая болж өсчээ. Оросын өөрийнх нь нутаг дэвсгэрт 1987-1995 онд ядуучуудын тоо хоёр саяас 66 сая болж нэмэгджээ. ДБ-ны жишгээр авч үзвэл, Орос зэрэг тийм орнуудын

хувьд ядуурлын босго нь өдөрт дөрвөн доллар хүртэл орлогыг хэлдэг байна. Хөгжиж буй олон орны хувьд өдрийн хоёр долларын орлогын төвшинг ядуурлын босго гэж үзэж байгаа билээ.

Хүн амын, түүний дотор ТУХН-ийн орнуудын хүн амын нэлээд хэсэг ядуурч байгааг дагалдан эд хөрөнгийн тэгш бус байдал түргэн ихсэж байна. ДБ-ны мэргэжилтнүүд Оросыг үндэсний орлогын тэн хагасаас илүү нь хамгийн чинээлэг иргэдийн 20 хувьд ногдож, харин үндэсний орлогын тав хүрэхгүй хувь нь хамгийн ядуу иргэдийн 20 хувьд ногддог орнуудын тоонд оруулжээ. “Тодорхой утгаар авч үзвэл шилжилтийн эдийн засагтай орнууд эд хөрөнгийн тэгш бус байдал болон хөгжлийн хурдцын хооронд харилцан холбоо байдаг гэсэн эдийн засгийн хуулийг няцаав. Эдгээр орон хасах өсөлт гарч, тэгш бус байдал ихсэж, өөрөөр хэлбэл хоёр тал хохирч болно гэдгийг харууллаа” гэж ДБ-ны тэргүүлэх эдийн засагч Жозеф Стиглиц илтгэлийг танилцуулахтай холбогдуулан мэдэгдсэн юм.

ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоолсноос үзвэл, хэрвээ хөгжиж буй орнуудад эдийн засгийн талаар хангалттай тусламж үзүүлэхгүй бол хөгжиж буй ертөнцөд ядуусын тоо жилд 30 сая хүнээр нэмэгдэх ажээ. Гэтэл одоо санхүүгийн хямралаас болоод энэ тусламж багасч байна. Тухайлбал 1997 онд хөгжиж буй орнуудад 299 тэрбум долларын хувийн хөрөнгө оруулсан бол, 1998 онд 227 тэрбум доллар болж буурчээ. Гэвч банкны зээлийн салбар болон хувьцаа, өрийн үүргийг худалдан авахад энэ тусламж хамгийн ихээр буурсан бөгөөд 1997 онд 135 тэрбум доллар байсан бол, 1998 онд 72 тэрбум доллар болсон байна. Үүний хамт үйлдвэрийн газар, компаниудын секторт гадаадын шууд хөрөнгө оруулалт ингэж эрс буураагүй юм.

Ийм хөрөнгө оруулалт 1997 онд 167 тэрбум доллар байсан бол, 1998 онд 155 тэрбум доллар болсон юм. Индонезоос бусад Азийн орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт идэвхтэй орж байв. Энэ орны улс төрийн түгшүүртэй байдлаас болоод гадаадын шууд хөрөнгө оруулалт 1997 оныхоос 1998 онд зургаа дахин буурсан байна.

Хөгжиж буй орнуудад хөнгөлттэй нөхцлөөр олгодог улсын тусламж 1998 онд 32,7 тэрбум доллар байв. Энэ нь 1997 оныхоос нэлээд доогуур, 1990 оныхоос гуравны нэгээр бага юм. 1997 оноос Бразил, Индонез, Өмнөд Солонгос, Орос, Тайландад

өгөхөөр амласан 190 тэрбум доллараас 63 тэрбумыг нь өгсөнийг ДБ тэмдэглэж байна.

Дэлхийн Банкнаас албан ёсны шугамаар үзүүлдэг тусламж 1997 онд 6%-иар буурсан нь сүүлийн 18 жилийн хамгийн бага үзүүлэлт юм. Гэвч үүний барагцаалбал тэн хагас нь аж үйлдвэр хөгжсөн олонхи орны валютын АНУ-ын доллартай харьцах ханш буурч, түүнчилэн Израилийг зарим талаар хөгжингүй орнуудын бүлэгт шилжүүлсэнтэй холбоотой юм. Энэ оронд их хэмжээгээр үзүүлдэг тусламжийг түрүүнд нь хөгжиж буй оронд үзүүлж буй тусламж гэж үзэж байсан юм. Тийнхүү тусламжийн бодит бууралт хоёр орчим хувь болж байна.

1999 оны байдлаар хөгжингүй 22 орноос хөгжиж байгаа орнуудад зориулж ДНБ- хээ хэдэн хувийг зориулж буй энд жишээ болгон авч үзье. Япон 0.35, АНУ 0.10, Франц 0.39, Герман 0.26, Англи 0.23, Нидерланд 0.79, Итали 0.15, Дани 1.01, Канад 0.28, Швед 0.70, Норвеги 0.91, Испани 0.23, Австрали 0.26, Швейцарь 0.35, Бельги 0.30, Австри 0.26, Финлянд 0.33, Португаль 0.26, Грек 0.31, Ирланд 0.15, Шинэ Зеланд 0.27, Люксембург 0.66 хувь буюу дундчилбал 0.24 хувь болж буурчээ.

Хөгжингүй орнуудаас урьд өмнө олгож байсан хэмжээний тусламжийг сэргээх хэтийн төлөв тийм сайн биш байна гэж ДБ-ны мэргэжилтнүүд үзэж байна. Ирланд, Швед, Их Британи гэсэн гурван орон л өөрсдийн төсөвт хөгжиж буй орнуудад туслах хөрөнгийг нэмэгдүүлэхээр зарлажээ. Голланд ч тусламжийн хөрөнгөө нэмэгдүүлж болох юм. Томоохон хандивлагч болох Япон эхлээд 1998 оны санхүүгийн жилд тусламжийн хөрөнгөө хорогдуулсан боловч, дараа нь нэмэлт төсвөөр энэ хөрөнгийг нэмэгдүүлсэн юм. Аж үйлдвэр хөгжсөн орнуудын хувьд хөгжиж буй орнуудад үзүүлдэг тусламж бүхэлдээ дотоодын нийт бүтээгдэхүүний 0,2%-иас доош буужээ.

Одоо тусламжийн ихээхэн хэсэг нь дайн байлдаан, байгалийн гамшигтай холбоотой онцгой тусламжинд зориулагдаж, үүний хамт хөгжлийн урт хугацааны зорилгод бага мөнгө гаргасан хэвээр байна. Нөгөө талаар хөгжингүй орнуудын захиргааны зардал ч ихээхэн өссөнтэй ямар нэгэн хэмжээгээр холбоотой.

Хөгжиж буй орнууд болон хуучин Дорнод Европын эвслийн орнуудын эдийн засгийн өсөлт ердөө 1.5% болж, 2000 онд 3.7%, 2001 онд 4.6% болж нэмэгдэнэ. Бразилын санхүүгийн хямрал

нэг үе болгоомжилж байсанчилан, Латин Америкийн бусад оронд тархаагүйг илтгэлд сэтгэл ханамжтай тэмдэглэжээ. Азийн зарим оронд, юуны өмнө Өмнөд Солонгос, Таиландад эдийн засаг өсөх шинж тэмдэг илэрч байна. АНУ, Европ болон Азийн зарим орны санхүүгийн зах зээлийн байдал сайжирч байна гэж Дэлхийн Банкны шинжээчдийн илтгэлд тэмдэглэжээ.

Дэлхийн Банкны шинжээчдийн үзэж байгаагаар дэлхийн эдийн засаг ойрын хэдэн жилд тогтворжин зөв голдиролдоо орж, эдийн засгийн өсөлт ажиглагдах болно гэсэн өөдрөг дүгнэлт хийсэн байна. Үүнийг одоо таамаглахад хэцүү. Цаг үе үүнийг харуулах биз ээ. Шинжээчдийн зарим дүгнэлт таамаглал тэр бүр амьдралд биелэлээ олдоггүйг бид мэдэх билээ.

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: ЭЭРЭГ СӨРӨГ ХАНДЛАГА

Глобалчлал нь дэлхийн бөмбөрцгийн аль хэсэгт оршихоос үл шалтгаалан том бага, хүчтэй хүчгүй бүх улсын эрх ашгийг адилхан хөндөж байна. Глобалчлалын асуудал шинэ зууны АНУ-ын үндэсний аюулгүй байдлын стратегид онцгой байр эзэлж байна. Уг стратегид тухайлан дурдахдаа “глобалчлал бол эдийн засаг, технологи, соёл, улс төрийн интеграц хурдсах үйл явц юм. Ингэхлээр манай орон гадаадад болж байгаа үйл явдлын нөлөөг улам бүр улам их мэдрэн амсаж байх болно. Хүлээн зөвшөөрөгдөөгүй улсууд, үндэстний мөргөлдөөнүүд нь дэлхийн олон чухал бүс нутгийн тогтвортой байдал, эдийн засгийн дэвшилд аюул занал учруулж байна. Үй олноор хөнөөх зэвсэг, терроризм, мансууруулах бодис дэлгэрүүлэх явдал, зохион байгуулалтай гэмт хэрэг бол улсуудын хил хязгаараас үл хамаарах глобал асуудлууд юм. Байгалийн нөөцийн хомсдол, хүн амын түргэн өсөлт, хүрээлэн буй орчинд учруулж буй хохирол, халдварт шинэ өвчин, хяналтгүй цагаачлал зэрэг урьд өмнө манайхаас нэлээд хөндий зайдуу мэт байсан асуудлууд өнөөдөр АНУ-ын аюулгүй байдалд хүчтэй нөлөөлж байна. Товчоор хэлбэл манай иргэд бусад орон цэцэглэн хөгжиж тогтвортой байгаасай хэмээн сонирхож байна. Бусад орон олон улсын хэм хэмжээ, хүний эрхийг сахин мөрдөж байгаасай, эдгээр орон олон улсын гэмт хэрэгтэй тэмцэж чадлаг байгаасай, тэдгээрийн зах зээл нээлттэй байгаасай, хүрээлэн буй орчныг хамгаалах талаар тавьж буй хүчин чармайлт нь амжилт олоосой хэмээн сонирхож байна.

Үүний сацуу манай энэ эрин үе бол их боломжийн эрин юм. Глобалчлал тив бүрийн хүмүүсийг ойртуулж, тэгснээр үзэл бодол, таваар мэдээлэл саадгүй солилцох бололцоог тэдэнд олгож байна. Дэлхийн олон орон төлөөлөн удирдах зарчим, зах зээлийн эдийн засаг, хүний үндсэн эрхийг хүндэтгэх явдал, хуулийг дээдлэх зэрэг Америкийн үндсэн гол үнэт зүйлсийг хуваалцаж байна. Энэ нь энх тайван, баян чинээлэг байдал, тэрчлэн улс орнуудын хоорондын илүү нягт хамтын ажиллагааг хангах хэтийн шинэ төлөв нээж байна. Бидний урьдын дайснууд одоо бидэнтэй хамтран ажиллаж байна. Глобал эдийн засгийн зарчим худалдаа, соёлын хэлхээ холбоог өөрчилж, олон сая америкчуудад ажлын шинэ шинэ байр бий болгож, эдийн засгийн бололцоо нээж байна” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Глобалчлалын өнөөгийн үйл явцын дүнд бусдаас илүү их үр шим хүртсэн АНУ хүртэл түүний зохисгүй үр дагаварыг мэдэрч эхэлж байгаа нь тэмдэглүүштэй, сайшаалтай хэрэг. Азийн “баруудын” валютын ханш буурч, тэдгээрийн бараа таваарыг худалдан авахад америкчуудын зарцуулдаг зардал багассны улмаас эдгээр оронд нийлүүлдэг америкийн барааны үнэ нэмэгдэв. Эцсийн дүнд АНУ-ын импорт нэмэгдэж, экспорт бууран, худалдааны тэнцэлийн алдагдал дээд хэмжээнд хүрчээ. Америкийн дэлхийн эдийн засгийн хүрээлэнгийн Моррис Голдстейны дүгнэснээр, АНУ-ын худалдааны алдагдал 1997 онд 180 тэрбум доллар байснаа 1998 онд 300 тэрбум хүртэл өсчээ. Энэ нь Америкт багагүй гай тарих аюултай юм. Вашингтоны тодорхой бүлгийнхэн эдийн засгийн глобалчлалыг “АНУ-ын глобал жанжлалын бодлого” гэж тайлбарлах нь олонтаа байдаг. Роберт Каган долоо хоног тутмын “Уикли стандарт” сонинд бичихдээ Америкийн бүх хүчин чадлыг “Умард Африк, Дундад Дорнод, шинэчлэн зэвсэглэсэн Герман, эмх замбараагүй Европ, сэргэж буй Орос, өндийж буй Хятад, шинэчлэн зэвсэглэсэн Япон, Америкийг эсэргүүцсэн лалын тулгуур үзэл өндийх явдлыг тогтоон барих зэрэгт чиглүүлэхийг” уриалжээ. Ингэхдээ “хэрэв Орос улс АНУ-ын эрх ашигт дайсагнагч орон болбол бид түүнийг эсэргүүцээд зогсохгүй бас оросын ард түмэн, оросын төр улс сэргэхэд саад болохыг хичээх болно” гэж онцлон тэмдэглэсэн байна. Энэ бүх зорилт нь “АНУ бусад улсын олон улсын хэрэг явдалд дайны дараах үед байгаагүй их цар хэмжээтэйгээр оролцож байхыг шаардах болно” гэж Каган нотолжээ.

Хэт давруу үзэлтнүүд хаа сайгүй байдаг хэмээн үзэж иймэрхүү үг яриаг үл тоомсорлож болох билээ. Гэхдээ дэлхий дээр цорын ганц хэт их гүрэн хэвээр үлдсэн оронд иймэрхүү яриаг нийтийн өмнө дэлгэж байгаа нь тун ноцтой хэрэг юм. АНУ 1993 оноос хойш 85 орны эсрэг 60 удаа дангаараа эдийн засгийн хориг арга хэмжээ авсан юмуу хууль тогтоомжийн арга хэмжээ авахаар сүрдүүлсэн байна. Тэдгээр оронд дэлхийн хүн амын 40 хувь нь аж төрж байлаа гэсэн тооцоо гарчээ.

Гэхдээ энэ үйл явцад АНУ-ын гүйцэтгэж байгаа зонхилох үүргийг глобалчлалд оролцогч бусад хэн бүхэнд хүсэл зоригоо империалист маягаар тулган хүлээлгэж байгаа хэрэг хэмээн үзэж болохгүй гэж Харвардын их сургуулийн профессор С.Хофман үзэж байна. Хүйтэн дайн дууссанаас хойш АНУ-ын олон нийт өөрийн орныг аливаа улсын эсрэг хориг арга хэмжээнд оролцохыг сайшаахаа больсон билээ. Тийм ч учраас “америкийн албаны хүмүүсийг ам мэдэн ярих үед АНУ-ын олон нийт дүгнэлт хийхдээ НАТО-г хэвээр байлгаж байгаагийн үндсэн шалтгаан нь европчууд нөхцөл байдалд нийцүүлэн богино хугацаанд шуурхай арга хэмжээ авч чаддаггүй, нэгдэл нягтарал сул, тархай бутархай, арчаагүй байгаад л хамаг учир нь оршино гэсэн ойлголттой байдаг аж. Тэднийг ганцааранг нь орхивол тэд алдаа гаргаж, түүнийг нь америкчууд л зохицуулахад хүрнэ” гэж шууд хэлдэг болсон байна.

Глобалчлалын үйл явц нийгмийн амьдралын бүхий л хүрээ, эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын салбарт нэгэн зэрэг хөгжих ёстой гэсэн үзэл санаа бүх санал шүүмжлэлд нэвт шингэсэн байна. Чухам тийм хандлагад аяндаа орох магадлал бага юм. Тухай тухайн улс үндэстэний эсэргүүцлээс гадна иргэний бүтэц, угсаатны ялгаа нөлөөлж байгаа юм. Улс, ард түмнүүд үндэсний өвөрмөц байдлаа хадгалахыг эрмэлзэж байна. Глобалчлалын үйл явцыг шууд эрхлэн хөтөлж байгаа болон түүнийг хөндлөнгөөс ажиглан, нөлөөг нь өдөр тутмын амьдралдаа мэдэрч байдаг хүмүүсийн аль алинаас их зүйл шалтгаална.

Дэлхийн эдийн засгийн тулгамдсан асуудлаар дэлхийн нэртэй том бизнесменүүд, улстөрчид, эрдэмтэд, олон улсын болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид цугларч санал бодлоо солилцдог уламжлалт Давосын уулзалт 1999 онд болсон уулзалтаараа “Глобалчлалыг удирдах асуудал”-ыг тусгайлан авч хэлэлцсэн нь санамсаргүй хэрэг биш байлаа. Ази, Орос, Бразилид болсон

санхүүгийн хямралаас үүдсэн донсолгоо АНУ-д ч ноцтой түгшүүр төрүүлсэн юм.Тухайлбал, АНУ-ын сангийн яамны орлогч сайд Лерри Саммерс “глобалчлал гэдэг хямралын нян америкийн эдийн засгийн яг зүрхэн тус газар халдварлаж болно гэсэн үг юм” гэж тэмдэглэжээ. “Хэрэв дэлхийн өөр бусад хэсэг санхүүгийн хямралд нэрвэгдвэл АНУ “сайн, сайхан байдлын баян бүрд” хэвээр үлдэж чадахгүй” гэж АНУ-ын Улсын нөөцийн газрын тэргүүн Аллан Гринспэн хэлжээ

Асуудлын улс төрийн тал ч багагүй түгшүүр төрүүлж байна.Тухайлбал АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга байсан Генри Киссинжер Давост үг хэлэхдээ олон улсын санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа дэлхийн олон орны засгийн газар огцрох үйл явцыг дэмжин турхирч, нийгмийн түгшүүртэй байдлыг хурцатгаж байна гэж хүлээн зөвшөөрчээ.Олон улсын валютын сангийн үйл ажиллагаа дотоодын бэрхшээлийн эх үүсвэр болж байгаа учир эдгээр орны удирдлагын хувьд хүлээн авч болошгүй зүйл болж, тэгснээр эдгээр орныг Өрнөдөөс хөндийрүүлэхэд хүргэж байгаад түгшиж байгаагаа Киссинжер илэрхийлжээ.

Давост хамгийн олны анхаарал татсан зүтгэлтний нэг байсан Малайзийн ерөнхий сайд Мохатхир болон ерөөс Малайзийн жишээ хамгийн тод томруун байлаа. Малайз улс Олон улсын валютын сантай хамтран ажилладаггүй бөгөөд төрийн хатуу зохицуулалтад тулгуурласан өөрийн гэсэн эдийн засгийн стратеги баримталдаг нь тэмдэглүүштэй юм. Дашрамд дурдахад өнөөдөр Малайзын эдийн засгийн байдал ОУВС-ийн жороор ажилладаг бусад орнуудынхаас сайн байгаа билээ. Энэ бол нийтлэг журмаас гадуур байдаг нэг онцлог уу? Тийм байж болох юм. Гэхдээ энэ бол Киссинжерийн хувьд америкийн нөлөө суларч байгаагийн түгшүүрт шинж тэмдэг аж.

“ОУВС-ийн өөрийнх нь зөвлөмжүүд зарим талаар хөнөөлт хүчтэй үйлчилгээтэй болохыг ердөө ойлгохгүй байгааг Ази, Оросын туршлага харуулж байна. Олон улсын валютын сан Зүүн Азид явуулсан бодлогодоо 1998 он гэхэд Индонез, Солонгос, Тайландын эдийн засгийн өсөлт 3 хувь болно гэдийг иш үндэс болгосон юм. Гэтэл энэ нь эсрэгээр эргэж тус сангаас явуулсан бодлого тэдгээр орны эдийн засгийг сүйрэлд хүргэв. Солонгос,Тайландад дотоодын нийт бүтээгдэхүүн 7 хувиар, Индонезид 15 хувиар буурав.Орост явуулах ОУВС-ийн бодлого рублийн тогтвортой байдлыг хангаж,

шинэтгэлийг дампуурлаас хамгаална гэж тэд үзэж байв. Гэтэл бүх зүйл эсэргээр эргэж, зээлийн өндөр хүү оросын эдийн засгийг орвонгоор нь эргүүлж, рубль нурсан билээ” гэж монголчууд бидний сайн мэдэх Харвардын их сургуулийн профессор Жеффри Закс эгдүүцэн бичжээ. Массачусетсийн технологийн дээд сургуулийн профессор, америкийн нэрт эдийн засагч Рудигер Дорнбуш Бразилиас Орос хүртэл бүх дампууралд холбоотой ОУВС-ийн удирдагч Мишель Камдессю огцруулахыг шууд уриалж байжээ.

Эдийн засгийг глобал байдлаар удирддаг өрнөдийн санхүүгийн байгууллагуудыг өрнөдийн дээдэс ийнхүү эсэргүүцэн боссон нь тохиолдлын санамсаргүй хэрэг огтхон ч биш. Дэлхийн санхүүгийн системийг өөрчлөн байгуулах зайлшгүй шаардлагатай байгааг “Их найм” нэгэнт хүлээн зөвшөөрсөн билээ. Гэхдээ Өрнөд болон түүний олон улсын механизмыг эсэргүүцсэн эсэргүүцэл дан ганц эдийн засгийн хүрээг хамраагүй болохыг хэлэх нь зүйд нийцнэ. Харвардын профессор Сэмюэл Хантингтон “Соёл иргэншлүүдийн мөргөлдөөн” хэмээх шуугиан тарьсан бүтээлдээ глобалчлал хэмээх хөөрлийг ойшоож үзэхгүй байгаагаа шууд илэрхийлсэн юм. Тэрбээр “түгээмэл соёл иргэншил” хэмээх нэр томъёог эсэргүүцээд, түүний цаана өрнөдийн соёл иргэншил буюу “давосын соёл” гэгч явцуу ойлголт нуугдаж байна гэж үзсэн нь түүний зөв биз ээ.

Хантингтон бичихдээ, “Давост тогтмол ирж байдаг хүмүүс үнэндээ олон улсын бүх байгууллага, дэлхийн олон орны засгийн газар, дэлхийн эдийн засаг, цэргийн дийлэнх чадамжийг хянаж байдаг юм. Ийм учраас Давосын соёл туйлын чухал. Гэхдээ дэлхийн хэмжээнд энэ соёлыг хэдэн хүн хуваалцаж байдаг бол? Өрнөлөөс цааш түүнийг 50 хүрэхгүй сая хүн, өөрөөр хэлбэл дэлхийн хүн амын нэг хүрэхгүй хувь хуваалцдаг байж болох юм. Иймээс энэ соёл огт түгээмэл биш бөгөөд түүнийг номлодог тэргүүлэгч нар өөр өөрсдийн нийгэмд эрх мэдлийг найдвартай хянаж байх албагүй билээ” гэжээ.

Хантингтоны бүтээл нь нэг талаас өрнөдийн глобалчлагчид, нөгөө талаас шинэ тулгар хэд хэдэн орны өрнөдийн тал баримтлагч дээдсийг илэрхий чангахан чимхсэн хэрэг болсон билээ.

“Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах нь үнэхээр чухал. Гэхдээ нийгэм, түүний хөгжилд мөнгөнөөс дутуугүй чухал зүйл байдаг. Хэрэв та бүхэн үүнийг анхаарч

үзэхгүй бол олигтой үр дүнд хүрэхгүй. Эцсийн эцэст бүх зүйл хүнээс шалтгаалдаг... Жишээлэхэд, Оросын соёл, нийгэм, улс төрийн хэмжүүр хамгийн их сэтгэл түгшүүлж байна” гэж Дэлхийн банкны ерөнхийлөгч Жеймс Вульфенсон хүлээн зөвшөөрчээ.

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас явуулж байгаа жигдлэх бодлогыг орон нутгийн соёл, эдийн засагт хэрхэн зохицуулах вэ гэсэн асуулт одоо гарч байна. “Глобалчлалыг амжилттай болгоё гэвэл түүнийг урсгалд нь тавих ёсгүй” гэж Энэтхэгийн Сангийн яамны сайд Яшвант Сингх үзэж байна. Үүнийг үл зөвшөөрөхөд бэрх юм. Глобалчлалыг зогсоох боломжгүй. Гэхдээ түүнийг илүү удирдлагатай, илүү ухаалаг болгох нь зайлшгүй чухал гэж Давосын чуулганд оролцогчид үзжээ.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан 1999 оны нэгдүгээр сарын 31-нд Давост дэлхийн чуулга уулзалт дээр хэлсэн үгээ глобалчлалын нөхцөлд олон улсын ажил хэргэгч хүмүүсийн хүлээх хариуцлага гэсэн чухал сэдэвт зориулсан билээ. Түүний хэлсэн үгийн агуулга дэлхий нийтийн ч, орон нутгийн ч шинж чанартай байв. Учир нь дэлхийн янз бүрийн бүс нутаг болон тухайлсан нэг орны аль алинд тулгарч байгаа асуудлыг К.Аннан дэвшүүлсэн юм. Дэвшүүлсэн асуудлуудыг шийдвэрлэх, эдийн засгийн үйл явцад татагдан орсон хүмүүсийн эрх ашиг, үндэсний эдийн засгийг хамгаалахын тулд янз бүрийн оронд олон улсын байгууллагууд, үндэстэн дамнасан корпораци, компанууд, эдгээр корпораци, компани үйл ажиллагаагаа явуулдаг орнуудын засгийн газар хамтарсан, уялдуулан зохицуулсан хүчин чармайлт тавих шаардлагатай байна. Монгол дэлхийн эдийн засгийн хамтын нийгэмлэгт улам бүр татагдан орж байгаа хийгээд энэ зуунд манай оронд глобалчлалын нөлөө ихээхэн тусч буй учраас энэхүү бүтээлд Давосын чуулган дээр К.Аннаны хэлсэн үгнээс заримыг дурдах нь зүйтэй юм.

Тэрбээр хэлэхдээ, “ Урагш дахин нэг алхам хийхийг би өнөөдөр хамтын нийгэмлэгийн удирдагчдад уриалахыг хүсч байна. Дэлхийн зах зээлийг хүнлэг шинжтэй болгоход чиглэсэн ерөнхий зарчмууд, үнэт зүйлсийг тусгасан манай байгууллагын глобал гэрээнд нэгдэн нийлэхийг би тэдгээрт уриалахыг хүсч байна.

Нэгдэх нь амин чухал асуудал мөн. Гэхдээ бид энэ асуудлын сайн талыг хэтрүүлэн үнэлэх вий хэмээн айж байна. Зах зээл өргөжих цар хэмжээ нь компануудын бололцоо, тэдгээрийн улс

төрийн системийн шинэ нөхцөлд дасах бололцооноос хавьгүй их түрүүлж байна. Гэтэл улс төр, эдийн засаг, нийгмийн системийн хоорондын уялдаагүй байдал урт удаан хугацааны турш үргэлжилж чалдаггүйг бид түүхийн туршлагаас мэднэ” гэжээ.

Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт хэмээн нэрлэсэн Давосын чуулга уулзалтын эргэн тойронд дээр өгүүлсэнчлэн янз бүрийн үзэл бодол, үйл явц өрнөсөөр байна.

Дэлхийн улс орнуудын төр засгийн тэргүүн нарын мянганы чуулга уулзалт болон бусад баримт бичигт глобалчлалын нөхцөл дэх дэлхийн эдийн засгийн байдал хэлэлцэх асуудлуудад гол байр суурь эзэлсээр ирлээ. 2001 оны Давосын ээлжит уулзалтад дэлхийн нэр цуутай 1500 орчим эрдэмтэд, улс төрчид, бизнесменүүд оролцож мөн л глобалчлалын асуудалд зохих анхаарлаа хандуулсан билээ. Энэ 2002 оны ээлжит уулзалтын хувьд уламжлал ёсоор Давост бус Нью-Йоркт болно. Глобалчлалыг эсэргүүцсэн хүч идэвхжиж байгаа болон терроризмын эсрэг тэмцэлд дэлхийн улсууд дуу хоолойгоо нэгтгэх, АНУ-г дэмжих үүднээс зохион байгуулагч улс-Швейцарын тал энэ сонголтыг хийсэн аж. Энэ жилийн уулзалт өнөөгийн эриний тулгамдсан олон тооны асуудал хэлэлцэх юм. Түүний дотор мэдээж хэрэг глобалчлалын асуудал ч хөндөгдөх болно.

(үргэлжлэл нь дараагийн дугаарт)

АШИГЛАСАН ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. Stanford Business School Research Report: Wacziarg: Economic...
... Stanford Business School. ...Economic Globalization. Expect More, Smaller Countries with ...
<http://www.gsb.stanford.edu/research/report/2001/wacziarg.html>
More Results From: <http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.gsb.stanford.e>
2. http://srd.yahoo.com/goo/report+of+economic+globalization/2/*http://ifg.org/bey Beyond the WTO Alternative to Economic Globalization A Preliminary Report by a Task Force of the International Forum on Globalization ~ Release Date: November...
<http://www.ifg.org.beyondwto.html>
More Results From: <http://google.yahoo.com/bin/>

query?p=report+of+economic+globalization&hq=site

3. Economic Policy Institute trade and globalization ...architecture. The first, Meltzer Report Misses the Mark, argues... it has created much economic instability and ...on trade and globalization Read opinion pieces... More Results From: <http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.epinet.org>
4. South Asian Economic Issues, Indian Subcontinent-...
...760cr, Jayanti Ayangar (Economic Times) wrote about ...to exporters. The detailed report suggested that with...solve pressing problems, globalization has actually ... http://members.tripod.com/~INDIA_RESOURCE/globalization.html
More Results From: members.tripod.com
5. Globalization and Citizenship
...Globalization and Citizenship. Report of the UNRISD International Conference...the state: Responses to economic globalization: Globalization from below...
<http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.unrisd.org>
6. Globalization and its impact
...out in his report to the Millennium Summit, globalization is the most important factor defining the quality of human existence. Unbridled economic... <http://www.unrichr.ch/Huridoca.nsf/2848af408d01ec0ac1256609004e770b/21a92d3d0425a500484s2f?OpenDocument>
More Results From: <http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.unhchr.ch>
7. Globalization Policy Forum-Globalization; Economic Liberalization...1980-2000 (August 19, 2001) This joint ATTAC-CERR socio-economic report argues that globalization has led to "diminished progress" in terms economic growth ...
<http://www.globalpolicy.org/globaliz/econ/>
More Results From: <http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.globalpolicy.or>
8. Mapping Progress (March 1998)-Press Advisory
...Rights, WEDO's report, Mapping Progress: Assessing Implementation of the Beijing Platform for Action, spotlights the ways in which economic globalization is... <http://www.wedo.org/monitor/mapping.htm>

More Results From: [http://google.yahoo.com/bin/
query?p=report+of+economic+globalization&hq=site:www.wedo.org](http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.wedo.org)

9. China News and Report

Economic Globalization and the Role of the Chinese Government.—The Third China Development ...

[http://www.china.org.cn/baodao/english/newsandreport/2001may/
new10-2.htm](http://www.china.org.cn/baodao/english/newsandreport/2001may/new10-2.htm)

More Results From: [http://google.yahoo.com/bin/
query?p=report+of+economic+globalization&hq=site:www.china.org.cn](http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.china.org.cn)

10. Economic and Fiscal Policy

...and Policies for Economic Rebirth” (Jul.5,1999); Report of the Globalization Committee June 1999. Economic Council (Jun.29,1999); Overview of Joint Report of the...

<http://www5.cao.go.jp/keizai/index-.html>

More Results From:

<http://www5.cao.go.jp>

11. INDG Annual Report 1999

... .. Annual Report 1999...for Peace civil society conference.

The activists shared a concern about the effect of economic globalization on world peace ...

<http://www.indg.org/report99.htm>

More Results From: [http://google.yahoo.com/bin/
query?p=report+of+economic+globalization&hq=site](http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site)

12. APEC - ABAC

... .. Annual ... 2000 ABAC Report to Economic Leaders: Facing Globalization the APEC Way Download self-extracting zipped file in MS World 6 format ...

<http://www.apecsec.org.sg/abac/abac.html>

More Results From: [http://google.yahoo.com/bin/
query?p=report+of+economic+globalization&hq=site: www.apecsec.org.](http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.apecsec.org)

13. Joint Center for Political and Economic Studies

...carried a special report on globalization, education, and technology and details how the Joint Center for Political and Economic Studies successfully partners... <http://www.jointcenter.org/>

More Results From: [http://google.yahoo.com/bin/
query?p=report+of+economic+globalization&hq=site:
www.jointcenter.org.](http://google.yahoo.com/bin/query?p=report+of+economic+globalization&hq=site:www.jointcenter.org)

14. AlterNet—Globalization

...of the World Population 2001, Report, which examines the close...much more control over their economic policies. Bush's Challenge: Globalization Good for The Poor...

<http://www.alternet.org/? Issue AreaID=21>

More Results From: <http://google.yahoo.com/bin/>

[query?p=report+of+economic+globalization&hq=site:www.alternet.org](http://google.yahoo.com/bin/?p=report+of+economic+globalization&hq=site:www.alternet.org)
www.jointcenter.org

15. World Culture Report: Culture and economic development

... the first World Culture Report we have chosen to...models, or rather at economic and social policies world... of international and globalization the room for ...

http://www.unesco.org/culture/worldreport/html_eng/wcr1.shtml

More Results From: <http://google.yahoo.com/bin/>

[query?p=report+of+economic+globalization&hq=site:www.unesco.org](http://google.yahoo.com/bin/?p=report+of+economic+globalization&hq=site:www.unesco.org)

16. PREFACE: Mt. Olive Pickle Boycott Report

Report On The Mt. Olive Pickle Boycott... Free trade within the context of economic globalization subjects local communities, including farmers and ...

<http://www.nccusa.org/publicwitness/mtolive/preface.html>

17. ETHZ Researcht Report / Prof.Dr.Thomas Bernauer

... on the consequences of economic globalization for state's capacity to ...the relationship between economic integration and political ...to search the reasearch report ...

http://www.rereth.ethz.ch/gess/internat_rel/bernaier/pj.03.html

More Results From: <http://google.yahoo.com/bin/>

[query?p=report+of+economic+globalization&hq=site:www.rereth.ethz.ch](http://google.yahoo.com/bin/?p=report+of+economic+globalization&hq=site:www.rereth.ethz.ch)

18. ETHZ Zurich, CIS – Publications of Former Staffmembers

... the Challenge of 'Globalization': Growth Triangles in ...Armin Guhl), UBS Economic Research Januar 1996. ... Sustain Growth, Country Report, UBS Economic Research...

<http://www.ib.ethz.ch/ publications/former.htm>

More Results From:

<http://google.yahoo.com/bin/>

[query?p=report+of+economic+globalization&hq=site:www.rereth.ethz.ch](http://google.yahoo.com/bin/?p=report+of+economic+globalization&hq=site:www.rereth.ethz.ch)

19. economic globalization index

...to Financing for development – a report prepared by the Ecumenical Coalition for Economic Justice for the WCC); Economic

Globalization : A Critical View and an...

<http://www.ib.wcc-coe.org/wcc/what/jpc/globalization.html>

More Results From:

<http://google.yahoo.com/bin/>

[query?p=report+of+economic+globalization&hq=site:coe.org](http://google.yahoo.com/bin/?p=report+of+economic+globalization&hq=site:coe.org)

20 CHALLENGES OF THE GLOBAL CENTURY — Report of the Project on...

Challenges of the Global Century Report of the Project on Globalization... in many forms, of which economic globalization is only one. The central... <http://www.ndu.edu/inss/books/ChallGlobCen/SEC02.HTML>

More Results From: [http://google.yahoo.com/bin/](http://google.yahoo.com/bin/?p=report+of+economic+globalization&hq=site)
[query?p=report+of+economic+globalization&hq=site](http://google.yahoo.com/bin/?p=report+of+economic+globalization&hq=site)